

Манмин Мэдээ

№ 50 2014 оны 9-р сарын 7

“Там мэт Атопик арьсны үрэвсэл өвчнөөс Эзэн намайг эдгээж өгсөн юм!”

И Жей руг пасторын залбирлаар атопик арьсны үрэвсэл өвчнөөс эдгэрсэн хүмүүс Бурханд алдрыг өргөж байна

2014 оны эхээр арьсны үрэвсэлт атопик өвчнөөр шаналж байсан хүмүүс эрс шийдэмгий сонголт хийж байсан. Ахлах сургуулийн нэгэн охин атопик өвчнөөс болж амиа хорлосон, бол гуч гаруй насны нэгэн эмэгтэй атопик өвчин нь хүндэрсэн 8 настай охиноо боомилоод дараа нь өөрийнхөө амийг ч егүүтгэсэн байна.

Атопик (AD) гэдэг бол маш хүнд, эдгэрдэггүй ужиг өвчин, ихэвчлэн бага насны хүүхдүүдэд тусдаг байна. Яг нарийн тодорхой сайн мэдэгдэхгүй байгаа ч ер нь удамшлын гаралтай дархлалын системийг гэмтээдэг.

Арьсны хуурайшил, хэсэг газар загатнах, нян бактер, вирус, мөөгөнцөрийн халдвар, амьдрах орчин нөхцөл гээд хэд хэдэн шалтгаанаас болж энэ өвчин тусдаг гэсэн ойлголт байдаг.

Эрүүл Мэндийн даатгалын газраас 2008-2012 оны хооронд энэ өвчнөөр өвчилж эмнэлэгт хэвтсэн хүний тоо ойролцоогоор 1.04 сая хүрсэн гэсэн мэдээ байгаа ч яг үнэндээ өвчтөний тоо хамаагүй их дунджаар 6.1 сая хүн байдаг байна.

Мөн дэлхийн хүн амийн бараг 20% нь атопик өвчнөөр шаналж байгаа бөгөөд бага насны хүүхдийн өсөлтөнд сөргөөр нөлөөлж байна. Энэ нь өөрийгөө авч явах чадваргүй юм уу эсвэл өөрийгөө үнэлэх чадварын доройтол гэх мэт сэтгэцийн өөрчлөлт нөлөөлж улмаар дэлхийн хэмжээнд тавигдах хүнд асуудал болоод байна.


Хэдий тийм боловч Манмин Төв Сүмийн олон итгэгчид энэ аймшигт өвчнөөр Пак Мин хэ (Знастай, Зураг 1), И Мин шиг (9 настай), Ким Еэ жи (12 настай), Пак Се рим (12 настай), Ю Сион ри эгч дүүс (15настай), Жү Хуа жин эгч дүүс (19 настай), Ким Сү гёон (29 настай, зураг 2) зэрэг итгэгч өвчилсөн бөгөөд Бурханы агуу хүчээр эдгэрэн, одоо аз жаргалтай амьдарч байгаа билээ.

Хүмүүс өөрсдөө чин сэтгэлээсээ гэмшсэний дараа эрх мэдэлт хүнтэй залбирал авахад атопик өвчнөөсөө бүрэн эдгэрсэн юм

Ким Сү бин эгч дүүс (26 настай, зураг 3) 4 настайгаасаа эхлээд атопик өвчнөөр өвчилж их шаналж байсан. Дунд сургуулийн сурагч байхдаа хавдаж идээлсэн нүүрээ нуухын тулд зуны халуунд ч маск зүүдэг байжээ. Оюуган болсоны дараа байдал улам дордож, хэцүү болсон байна. Энэ үед л тэр өөрийн өнгөрсөн амьдралаа эргэн харж, Бурханы дургүй зүйлүүд, үзэн яддаг юу болохыг ухаарч, энэ дэлхийн зүйлсийг таслан зогсоож, гэмшиж эхэлжээ. Дараа нь И Жей руг пастораас залбирал авахад түүний өвчин ор мөргүй эдгэрч цоо эрүүл болсон байна.

Одоо Ким эгч дүүс маань Иммануэл найрал дууны хамтлагын гишүүн болж итгэмжтэйгээр ажиллаж байгаа. Тэр “нүүрээр дүүрэн идээтэй шарх, шүүс нь гоожоод ердөө ч сайн унтаж чаддаггүй байсан. Харин одоо маш сайн унтаж байгаа. Би их аз жаргалтай баяртай байна” гэж ярьсан билээ. Тэр Бурханд бүх алдар магтаалыг өргөж хөгжмийн сургуульд суралцаж байна.

Мөн Пак Сэ хэ эгч дүүс (22 настай, зураг 5) нь атопик өвчнөөр маш хүнд өвчилж байсан бөгөөд эмч нар хүртэл толгой сэгсэрэн харамсдаг байжээ. Гэтэл мөн л И Жей руг пасторын өвчин эдгээх залбирал авсаны дараа 2-3 хоногын дараа бүх биеийн яр шарх болон шүүс болон идээ гарч байсан хэсгүүдэд нь тав суун эдгэрч эхлэн арьс нь төлжиж цэвэрхэн шинэ



арьстай болж бүрэн эдгэрсэн төдийгүй ямар ч баптагүй болсон байна.

И Сү жон (12 настай, зураг 6) гэдэг энэ хүүхэд нь 3 настай байхдаа атопик өвчний өөр нэгэн төрөл болох арьс, салст нь бижрүүтэн идээлэн дараа нь ховхорч унадаг ба шарх нь улам гүнзгийрч буй хүүхдээ харахад эцэг эхийн сэтгэл урагдах шиг болж байлаа гэв. Түүний аав И Дэй сүн сүмд үйлчлэгч, ээж Ким Юми сүмд үйлчлэгч нар балчир хүүхдийн өвчин нь ихэвчлэн аав ээжийн хийсэн гэм буруугаас болдог гэдгийг санаж итгэлийн амьдралаар идэвхгүй, бүлээн байсандаа гэмшиж И Жей руг пасторын залбирал авсан юм.

Залбирал авсаны маргааш өглөө нь нялцайж шүүс нь гоождог байсан шарх нь хатаж хуурай болж, идээтэй хэсэг нь хатаж хар тав тогтсон байв. Тэр оройдоо л шархны тав нь унаж залбирал авснаас хойш гурав дөрвөн өдрийн дараа бүрэн эдгэрсэн байна. Түүнээс хойш тэр эрүүл саруул аз жаргалтай өсөж, одоо Хүүхдийн цуглааны магтаалийн бүжгийн хамтлагийн гишүүн юм.

Түүнчлэн И Жи ёон эгч дүүс (21настай) нь атопи өвчнөөр шаналж, тэсэхийн аргагүй загатнадаг байсан учраас гараа марлиар чанга ороогоод унтдаг байсан бол Рю Ну ри эгч дүүс (14 настай) найзуудаасаа болоод зуны халуун өдөр байсан ч богино ханцуйтай цамц, шорт өмсөж чаддаггүй байлаа. Энэ хоёр хоёулаа И Жей руг пасторын залбирлаар цэвэрхэн төгс эдгэрсэн юм.

Гадаад оронд Мүан Амтат ус болон Гар алчуурын залбирлаар маш олон хүн Атопик өвчнөөс эдгэрсэн

Дэлхийн Эмч нарын Мексик дэх Холбооны захирал Даниел Фюентис Акоста докторийн хүү Даниел төрсөн цагаасаа хойш л гар, хөл нь атопик өвчнөөр өвчилсөн байжээ. Манмин төв Сүмийн сайн мэдээний баг Мексикт очих үеэр Доктор Фюентис Мүан Амтат усыг итгэлээрээ хэрэглэж, уувал гайхалтай эдгэрэл явагддаг тухай сонсоод хүүдээ өгчээ. Гэтэл гайхамшигтай зүйл болж Бурхан хүүг нь долоон өдрийн дотор бүрэн төгс эдгээн эрүүл болгожээ.

Африк, Кения улсын Эрик (8 настай, зураг 4) төрсөний дараах гурван долоо хоногтой байхдаа атопик өвчнөөр өвчилж эхэлсэн. Түүний нүүр царай нь тэр чигээрээ битүү яр шархтай, маш муухай үнэртэй байсан тул хотоос зайдуухан авч явжээ. Доктор Жон Мёон хо (Найроби Манмин Ариун Сүмийн хариуцагч пастор) пастор нь И Жей руг пасторын залбирч өгсөн гар алчуураар тэр хүүгийн төлөө залбирч өгсөнөөс хойш гуравхан долоо хоногийн дараа эдгэрч одоо түүний арьс нь яг л нялх хүүхдийнх шиг болсон байна (Үйлс 19:11-12).

Энэ өвчнийг анагаах ухааны аргаар эмчилэхийн тулд маш их тэсвэр тэвчээр, хичээл зүтгэл хэрэгтэйгээс гадна уйгагүй удаан хугацааны эмчилгээ шаардлагатай. Мөн маш их өндөр өртгөөр эмчлэх бөгөөд энэ нь бүрэн эдгэрдэггүй, дахин сэдэрх магадлал өндөр байдаг. Харин Эзэн дотор хариултаа авч, эдгэрсэн итгэгчид нь Бурханы өмнө байсан гэмийн ханаа нураагаад, итгэлээрээ залбирал авахад л ямар ч шарх сорвигүй, өвдөх зовиур, хүндрэлгүй, бүр мөсөн эдгэрсэн гэж ярьцгааж байна.

Энэ цаг үед ч хамтдаа байж биднийг эдгээж буй амьд оршигч, Эдгээгч Бурхандаа бүх алдар, магтаал, хүндэтгэлийг өргөцгөөе.

Атопик хэмээх арьсны идээт үрэвсэл өвчин нь маш их зовиур, өвдөлт, болон загатнадаг аймшигтай өвчин юм. Гэсэн ч Бурханд итгэж, найдан Түүнээс зуурах л юм бол өмнөхөөс нь ч илүү цэвэрхэн цагаахан, арьсыг өгөөд зогсохгүй чин үнэнч итгэлийг бэлэг болгон өгсөн юм.

Өршөөнгүй байх мэргэн ухаан

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж” (Иаков 3:17).



И Жей руг Тэргүүн пастор

Хэрэв бид амин хувиа хичээх хүслээ хаяж, Бурханы Үгийн дагуу, үнэн дотор явж чадвал тэнгэрлэг мэргэн ухааныг авч, сүнсээрээ илүү сайхан, амар тайвныг мэдэрч чадна. Үнэн, зөв гэж юу болохыг хялбархан ялгаж чаддаг болоод зогсохгүй бусдын сайн сайхны төлөө амьдрах хэцүү биш харин ч их амархан байх болно. Тэр ч байтугай тухайн үед хэцүү зовлонтой, хохирол амсаж буй мэт байвч Бурхан илүү агуу ивээл ерөөлөөр хариулж өгөх болно гэдэгт итгэн, хэдий тийм биш байсан ч үнэнийг үйлдэхдээ илүү аз жаргал баяр хөөртэй байж чаддаг юм.

Ингэж Бурханыг баярлуулдаг хүмүүс агуу их ерөөлийг авч чаддаг. Тэд үнэний замыг маш сайн ухаарч, бусдын хүнд хэцүү асуудалд тодорхой хариу өгч чаддаг байна. Энэ бол өршөөнгүй байх мэргэн ухаанаар дамжуулан олж авсан үр жимс юм. Тэгвэл энэ мэргэн ухааныг олж авахын тулд бид юу хийх хэрэгтэй вэ?

1. Өршөөнгүй, зөөлөн байхын сүнслэг утга

“Өршөөнгүй байх” гэдгийг хэлний тайлбар толинд “сонор соргог, анхааралтай халамжтай, бусдад сайхан сэтгэлээр хандах, найрсаг, зөөлөн, өршөөнгүй” гэж тодорхойлсон байдаг. Тэгвэл сүнслэг утга нь зүрх сэтгэл нь үнэн, шударга байдлаар дүүрэхийн хамт үнэний эрх чөлөө бий болж, өөрийн бүх зүйлийг бүгдийг нь зориулж чадах сэтгэл юм.

Бид зөвхөн материаллаг зүйлээр ч төдийгүй цаг хугацаа, хичээл зүтгэл, анхаарал халамж, үйлчлэл, бүр өөрийн амь насаа хүртэл бүгдийг нь зориулмаар байвал зүрх сэтгэл үнэнээр дүүрэх ёстой. Арвин уудам үнэний зүрх сэтгэлээр Өөрийн бүх зүйлээ хэрхэн зориулах тухай хамгийн сайн үлгэрлэж өгсөн эрхэм бол Есүс билээ. Бурханы Хүү болох Есүс нь ямар ч гэм нүгэл байхгүй ба Түүний

зүрх сэтгэл нь тэр чигтээ үнэний уг үндэс бөгөөд зөвхөн Бурханы хүслийн дагуу амьдарч, Өөрийн бүх бүх зүйлээ зориулсан билээ.

Есүс сайн идэж ууж, унтаж амарч ч чадахгүй явж байсан ч тэнгэрийн хаанчлалын тухай тунхаглаж, өвчтэй хүмүүсийг эдгээж байлаа. Мөн хүмүүсийн төлөө нулимс урсган байж залбирч, маш шаргуу ажиллаж, эцэст нь хүмүүсийн төлөө тэдний сүнсийг аврахын тулд цусаа хүртэл урсгаж өгсөн. Авралыг авч мөнх амийг хүртэх гэмт хүмүүсийн төлөө ямар ч гэм нүгэлгүй атлаа загалмайд цовдлогдсон. Ингэж Тэр үй олон сүнснүүдийг аварч, тэнгэрийн хаанчлал руу замчилж чадсан юм.

Та бүхэн хэр зэрэг өөрийгөө бусдад зориулдаг вэ? Хэдийгээр том хэмжээний хохирол амслаа ч өөрийн зүйлсээ бусдад зориулж чадах уу? Хэрэв бид өөрийн эрх ашгийг хайж, өөрсдийн дуртай зүйлийг, өөрийгөө л хайрлаж, бардаж, өөрийн үзэл бодолдоо баригдаад байвал хэзээ ч өөрсдийгөө ялан дийлж, “өөрөө өөртөө” бууж өгч чадахгүй.

2. Өршөөнгүй байдлаар дамжуулан ирэх ивээл ерөөл

Энэ дэлхийд хүн өөрийн юмыг бусдад тараахгүйгээр сайн хадгалж чадсан нь ухаалаг гэгддэг. Нэгийг өгвөл өгсөнөөсөө илүүг авахыг бодож, ингэж чадвал ухаалаг хэмээн тооцогддог. Гэтэл Үйлс 20:35т Эзэн Өөрөө “Авахасаа өгөх нь илүү ерөөлтэй” гэж айлдсан байдаг.

Бид Эзэний нэрээр өгч, хуваалцах юм бол Бурханаас илүү их ерөөлийг авах болно. Энэ бол жинхэнэ мэргэн ухаан юм. Хэрэв бид өгье гэснээсээ илүү ихийг өгч, бусдад чин сэтгэлээсээ үйлчилвэл алдаж эндэхгүй, зовж зүдрэхгүй. Хүмүүсийн зүрх сэтгэлийг олж авах нь тухайн үед маш бага ашиг орлого олох байсан ч юутай ч харьцуулашгүй үнэ цэнэтэй зүйл юм. Чухамдаа энэ л эелдэг зөөлөн байх сэтгэлээс гарах мэргэн ухааны үр жимс.

Гэтэл хувиа хичээх, уурлах, шунах сэтгэлтэй байвал яагаад ч эелдэг байдлыг харуулж чадахгүй. Тиймээс эелдэг байх гэдэг бол хүн зөвхөн бүх зүйлээсээ шууд татгалзах биш харин хамгийн эхлээд ариун байдал, үнэнд дотор агуу уудам сэтгэлээр амьдарч, өөрийн бүх зүйлээсээ татгалзаж чаддаг байх хэрэгтэй.

Эхлэл 13-р бүлэгт Абрам, Лот хоёр Бурханаас ерөөл аваад мал нь өсөж үржихэд малчид нь хоорондоо бэлчээр, уснаас болж хэрэлдсэн. Тэр үед Абрам Лотод “Чиний өмнө энэ бүх газар байгаа биш үү? Чи надаас салж яваач. Хэрэв чамайг зүүн тийшээ явбал, би баруун тийшээ явъя. Хэрэв чамайг баруун тийшээ

явбал би зүүн тийшээ явъя” гэж эхлэл 13:9д хэлсэн байдаг.

Тэгэхэд Лот өөрийн эрх ашгийг харж хамгийн сайн өвс ногоотой, ус ундаа элбэгтэй газрыг сонгодог. Тэр үед Лот малчдынхаа хоорондох хэрүүл маргааныг сонсоод хатуу сануулга өгч анхааруулсан бол авга ах Абрахамын чихэнд хүрэхгүйгээр асуудал зөвөөр шийдэгдэж болох байсан. Тэгсэн ч Абрахам Лотод гомдоллож, дургүйлхээгүй харин ч ач тусыг нь мартан орхиж явсан Лотын бүх хүслийг биелүүлж, өөрийн хүслийг хойш тавьсан.

Лотын тусын тулд буулт хийсэн Абрахам юу ч алдаагүй, зовж шаналаа ч үгүй харин ч бүр өгсөнөөсөө илүү агуу ерөөл хүртсэн. Абрахам сайхан сэтгэлийг харуулж чадсан учраас Бурхан амласныхаа дагуу түүний газар нутгийг хойшоо, урагшаа, баруун, зүүн тийш тэлж, тоологдохын аргагүй үр удамтай болгосон. Тэр эелдэг зөөлөн, өршөөнгүй байж, бүхнийг сайхан сэтгэлээр л хийсэн тул Бурханаас агуу, бялхсан ивээл ерөөлийг өгсөн юм.

3. елдэг байдлаас ирэх эрх чөлөө

Иохан 8:32 т, “...Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө” гэсэн байдаг. Үнэний дагуу амьдардаггүй хүмүүст эрх чөлөөг нь хааж, чөдөрлөж байгаа юм шиг санагдаж магадгүй. Харин үнэнийг мэддэг, түүнийхээ дагуу үйлдэж амьдардаг хүмүүс жинхэнэ эрх чөлөөг мэддэг.

Жишээ нь, та нэг гэмт хэрэг юм уу хуулиас гадуур буруу зүйл хийчихээд, зугтаж эсвэл нуугдаж явбал цагдаа харангуутаа л айж сандрах болно. Харин хуулийн дагуу, ямар ч гэм буруугүй хүн бол цагдаа харсан ч айдас, түгшүүргүй эрх чөлөөтэй байх болно. Үүнтэй адил Бурханы хуулийн дагуу үнэн дотор амьдардаг хүн Бурханы хайрыг болон ивээл ерөөл авах арга замыг мэддэг учраас ямар ч айдасгүй байдаг байна.

Тухайлбал, танд Эзэний Өдрийг ариунаар сахиу итгэл байхгүй бол Ням гаригт худалдаа наймаа хийж болохгүй, дэлхийн зугаа цэнгэл хөөж, оролцохгүй байх хэрэгтэй гэсэн үг танд яг л эрх чөлөөг чинь боож, байгаа мэт сэтгэгдэл төрнө. Харин эсрэгээр чин сэтгэлээсээ Эзэний өдрийг сахиу ёстойгоо мэддэг хүн Эзэний Өдрийг сахиснаар Бурхан хэмжээлшгүй эрх мэдэлтэй, агуу Нэгэн гэдгийг сүнслэг утгаар нь ойлгож, амар тайван, ивээл ерөөлүүдийг авдаг. Тиймээс бид үнэнийг мэдсэнээр маш их эрх чөлөөтэй, үнэний дагуу амьдарч чаддаг.

Хэрэв бид үзэн ядах сэтгэлээ хаячихвал асар их эрх чөлөөтэй аз жаргалтай

байх болно. Үнэн биднийг гэм нүглийн боолчлол, дарамтнаас чөлөөлж эрх чөлөөтэй болгодог. Үнэний дагуу амьдардаггүй хүмүүсийг бид шүүн дүгнэж, буруутгаад байдаггүй харин тэднийг урамшуулж, зоригжуулан үнэнийг мэдүүлвэл үнэний дагуу амьдарч чадна.

“Зүрх сэтгэлээ сайнаар, үнэнээр дүүргэх” гэдэг нь зүгээр үнэн гэж юу болохыг мэдэж ойлгохыг хэлдэггүй. 1 Коринт 8:1д “...Мэдлэг ихэрхэг болгодог, харин хайр сургамжилдаг аж” гэсэн байдаг. Хэрэв бид үнэнийг зөвхөн мэдлэг төдий ойлговол маш бага зүйл мэдэж байна гэсэн үг. Тэгээд өөрсдийгөө бүгдийг мэддэг гэж бодоод бардам ихэрхүү болж болох юм. Жишээ нь, үнэнийг зөвхөн мэдлэг болгодог хүмүүс үнэхээр чин сэтгэлээсээ үйлчилж буй хүнийг хараад тун удалгүй түүнийг шүүж дүгнэн, гомдоллож магадгүй. Тэд түүнийг “өөрийгөө нэг их чухал хүн гээд бодчихож” гэж боддог ч харин өөрсдөө ах дүүгээ шүүн дүгнэдэггүй гэж худлаа ярьж байгаагаа ч мэддэггүй байна.

Үүнийг эсрэг, зүрх сэтгэл нь үнэнээр, хайраар дүүрэн хүмүүс мэдлэг ихтэй хүнийг хараад түүний итгэлийн хэмжээг олж хардаг. Тэд Бурханы Үгээс зөв, бурууг сайн ялгах чадвартай ч зарим нэгэн худал хуурмагыг бусдаас олж хараад тэдний алдаа дутагдалыг хайраар далдалж, тэднийг хүлээж, хүлээн зөвшөөрч чаддаг юм. Яагаад гэвэл өөрөө ямар их гэм нүгэл, алдаа дутагдалтай байхад нь Бурхан агуу хайраараа хайрласаныг ойлгож ухаараад бусдыг ч бас тэгж хайрладаг.

Өршөөнгүй зөөлөн сайхан сэтгэлтэй хүмүүс бусдад гомдоод, шархлаад байдаггүй. Хэн нэгэн тэдэнд хохирол учруулсан ч шүүж дүгнээд, гоморхож ялархаад, ад үзээд байдаггүй. Харин ч тэр хүнийг үнэний замаар удирдан замчилж, түүний сүнсийг аврахыг хичээдэг. Танд ийм зүрх сэтгэл байвал бусдыг жинхэнэ амь руу удирдан чиглүүлэх болно. Энэ бол сайхан сэтгэл, эелдэг зөөлөн байдлаас олж авсан мэргэн ухаан юм.

Хайр итгэлийн ах, эгч дүүс нар минь, бид үнэнээр дүүрч, сайхан сэтгэл, өршөөнгүй зан чанарыг олж авсан цагт л Бурханы агуу их хайраар дүүрэн байх болно. Бид бусдад өгөхдөө харамлах ч үгүй, хар буруу санах ч үгүй, бусдын сайн сайханд агаархах ч үгүй болдог. Бид бусдад тусалснаар тэд илүү сайн сайхан болж, харамгүй өгсөнөөр тэд илүү баяр хөөртэй болдог юм шүү.

Та бүхэн ч гэсэн сайхан сэтгэл, эелдэг зан чанарыг олж аваад, өгөх нь авахаасаа илүү ерөөлдөгийг ойлгож, үнэний эрх чөлөөг элдэж баяр хөөртэй байгаасай хэмээн Их Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Монгол Манмин Сүм

Мэргэлийн цаг

Мэргөл	Цаг
Их мэргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мэргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мэргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мэргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мэргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мэргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.gcntv.org

Бурханы хүүхэд болж дахин төрсөн хүмүүст Ариун Сүнсний ажил илэрхий байдаг

Та нарын зарим нь тийм байсан. Гэвч Эзэн Есүс Христийн нэрээр болон бидний Бурханы Сүнс дотор та нар угаагдсан, та нар ариусгагдсан, та нар зөвтгөгдсөн юм (1 Коринт 6:11).

Есүс Христийг хүлээж авч, Бурханы хүүхдээр дахин төрсөн хүмүүсийн зүрх сэтгэлийг өөрчлөх, гэмшиж, гэм нүглээсээ эргэх, Бурханыг хайрлахад нь хүмүүст туслах гэх мэт эдгээр үйлс нь Ариун Сүнсний хийдэг маш чухал ажил бөгөөд Түүний үндсэн үүрэг нь юм.

1. Бэлэг

Ариун Сүнсний бэлэг нь Бурханы хайран дотор онцгой ажил, үүргийг Ариун Сүнсээр дамжуулан үзүүлж, харуулахыг хэлж байгаа юм. Бурхан хайр нигүүлслээрээ хайртай хүүхдүүдээ маш олон төрлийн зүйлсийг өгдөг. Тэдгээрийг бүгдийг нь 'бэлэг' гэж болно. Аврал, эдгэрэл, хариулт авах нь итгэгчидэд ерөнхийдөө өгөгддөг бэлгүүд юм. Харин онцгойлон өгөгддөг Ариун Сүнсний бэлэг гэж байдаг.

Ариун Сүнснээс өгөгддөг бэлгүүд нь 1 Коринт 12-р бүлэгт гардаг мэргэн ухаан, мэдлэг, итгэл, эдгээх бэлэг авъяас, гайхамшигуудыг үйлдэх, эш үзүүлэх, сүнснүүдийг ялгах чадвар, олон төрлийн хэлээр ярих, хэлнүүдийг тайлбарлах чадвар юм. Бурхан хүн бүрийн зүрх сэтгэлийн гүнийг хүртэл маш сайн мэддэг учраас Өөрийн хүслийн дагуу бэлгүүдийг өгдөг.

Хамгийн агуу бэлэг нь 1 Коринт 13-р бүлэгт гардаг хайр юм. Сүнслэг бэлгийг авсан хэмжээгээр хүчирхэг болж, Бурхантай илүү гүн гүнзгий, ойр дотно харьцаатай болох тул Тэр биднийг хайрыг мөшгө хэмээн ятгаж, сүнслэг бэлгийг чин сэтгэлээсээ хүсэн тэмүүлэхийг хүсэж байгаа (1 Коринт 14:1).

Бурхан тэрхүү сүнслэг бэлгүүдийг Бурханы Хаанчлалын төлөө ашиглахыг хүсдэг. Түүнчлэн Бурханы үр хүүхэд мөн л юм бол сүнслэг бэлгүүдээс зайлсхийх биш харин 1 Коринт 12:31-т хэлсэнчлэн агуу бэлгүүдийг хүсэн тэмүүлэх хэрэгтэй. Хэрэв та пастор бол хонин сүрэгтээ яг үнэн зөв замыг зааж, Ариун Сүнсний ажлуудыг үзүүлж, амьд Бурханыг батлан харуулах хэрэгтэй.

2. Ухаарал

Бүтээгч Бурхан цорын ганц хайртай хүүгээ гэмтэнүүдийн төлөө өгсөн нь төсөөлөхийн аргагүй агуу хайр юм. Түүний хайр ямар өндөр, агуу, гүн болохыг ухаарвал энэ нь хүний хайр биш Бурханы агуу хайр юм.

Ариун Сүнс туслах юм бол Бурханы үзэн яддаг гэмийг хаях, зүрх сэтгэлээрээ болон амьдралаараа Түүнд таалагдах нь тийм ч хэцүү биш. Хэцүү байсан ч итгэлээрээ дуулгавартай байж, зөвхөн Бурханы алдрын төлөө хичээнгүйлэн зүтгэж чадна.

Хэдийгээр тийм боловч олон итгэгчид авралын баталгаагүйгээр амьдарч байна. Олон хүн Ням гаригт сүм рүү явдаг болохоор аврал авсан гэж боддог ч тэд гэм нүгэл, зөвт байдал гэж юу болох, Ариун Сүнсийг хүлээн аваагүй учраас шүүлт гэж юу болох, яаж шүүгдэхээ ч мэддэггүй.

Есүс бидэнд зөвхөн Ариун Сүнс болон усаар дахин төрөөд (Иохан 3:5) Бурханы хүслийг биелүүлсэн хүн л Тэнгэрийн Оронд орно гэдгийг маш тодорхой, ойлгомжтой хэлж өгсөн. Мөн бидэнд Туслагч Ариун Сүнсийг илгээж гэм нүгэл, зөвт байдал, шүүлтийн талаар ойлгуулж өгсөнөөр (Иохан 16:8) Тамын аймшигт шүүлтээс зугтаж чадна.

Тиймээс Ариун Сүнсийг хүлээн авсан Бурханы хүүхдүүд гэм нүгэлтэй цус урсган тэмцэж (Еврей 12:4), хорон муугийн аливаа хэлбэрийг цээрлэж (1 Тесалоник 5:22), зөвт байдлын хүчээр Тэнгэрийн орноос тавилгүй зуурах хэрэгтэй.

3. Ариун Сүнсний дуу хоолой, ятгалга, удирдан замчлал

Хэрэв Ариун Сүнс бидэнд нөлөөлж, зоригжуулж байгаа бол бүхнийг зааж, бүр Бурханы гүн зүйлсийг хүртэл ухааруулж өгнө (1 Коринт 2:10-11). Бид сатаны хүчийг нурааж, ирээдүйд болох зүйлийг эш үзүүлж, сүнслэг ертөнцийн илчлэлтийг хүлээн авч чадна.

Гэхдээ Ариун Сүнс бол үнэний Сүнс (1 Иохан 5:7) тул бид хир их үнэнийг зүрх сэтгэлдээ бий болгосон тэр хэмжээгээр л ажилладаг. Хэрэв бид бүх зүйлд залбирч, Бурханы төлөө бүхнийг итгэлээрээ үйлдэж байвал Ариун Сүнсний дуу хоолойг сонсож, Түүний ятгалга, заавар зөвлөгөөг хүлээн авч чадна.

Ариун Сүнсний тусламжтайгаар бидний явах зам маш тодорхой харагдаж байвал ажил төрөл, бизнесийн тал дээр ерөөл авч, Бурханд алдрыг өргөдөг. Тэр мөн бидэнд бусдад хэрхэн яаж зөвлөгөө өгөх, номлож байх үед ч юу хэлэхийг маань сануулж байдаг.

Туслагч Ариун Сүнс бидэнд яг л гэрийн багш шиг зааж сургадаг учраас Бурханы үгийг илүү сайн ойлгож, дуулгавартай байж чаддаг. Тэр бидний зүрх сэтгэлд нутаглаж юу хэлэх, юу хийхийг зааж, үнэнийг сануулж байдаг билээ.

Ариун Сүнсний ятгалга гэдэг нь ямар нэгэн зүйлийг хий гэж бидний сэтгэлийг удирдаж, хөдөлгөхийг хэлдэг. Хэрэв мацаг барих, хэсэг хугацаагаар залбирмаар санагдаад байвал энэ нь Сүнсний ятгалга мөн. Чин сэтгэлээсээ залбирч, дуулгавартай, итгэлтэй байвал Ариун Сүнсэнд хөтлөгдөж чадна.

4. Залбирах хүч

Ариун Сүнсээр дүүрсэн үед ядарч хүнд хүчир ажил хийсэний дараа залбирсан ч ядардаггүй. Нойрмоглох, дэмий хоосон бодол ч бодогдохгүй, итгэлээрээ баяр хөөртэй залбирч чаддаг. Мартсан сэдвийг хүртэл Ариун Сүнс сануулж залбируулдаг.

Мөн бидний бүх хэрэгцээг мэдэж байдаг. Тэр бас бидний сул дорой байдалд туслаж, Бидний өмнөөс Бурханы хүслээр зуучлан залбирч байдаг (Ром 8:26-27). Бидний зүрх сэтгэл Ариун Сүнснээс нэгдсэн үед Бурханд өргөл өргөж, Түүнд таалагдсан залбирлыг хийдэг.

Ариун Сүнсэн дотор хир их залбирсанаас шалтгаалаад бидний залбирлын хэмжээ Бурханд өргөл болон очих нь өөр өөр байдаг. Тиймээс хариулт, ерөөл нь өөр өөр байдаг байна. Бид өөрсдийнхөө хүрээнд, өөрсдийн бодлоороо залбирах биш харин Ариун Сүнсээр удирдуулан Түүний дотор залбирах хэрэгтэй. Тэгвэл Бурхан бүх зүйлийг хийхдээ хамтдаа хамгийн сайнаар хийж, бид хариултаа маш амархан авч чадна.

Ариун Сүнсэн дотор залбирахдаа чин сэтгэлээсээ зүрхнийхээ гүнээс бүх зүйлээ зориулан залбирах нь маш чухал. Бид үргэлж чин сэтгэлийн залбирал өргөх хэрэгтэй ч хамгийн эхлээд дэлхийг ялан дийлэх сүнслэг хүч чадал, гал халуун залбирах, сатаныг ялан дийлэх, Эзэний Үгийн дагуу амьдрахыг хүсэн гуйх хэрэгтэй.

Дараа нь Эзэний Үгээр зэвсэглэх нь маш чухал. Эзэний Үгийг өөрсдийн амийн талх болговол бид Ариун Сүнсний ятгалгыг нэг бүрчлэн маш тодорхой хүлээн авч чадна.

1990 оны 11 сард миний нөхөр Жон Мён хо пастор Манмин Сүмд нэгэн танилынхаа урилгаар очиж И Жей руг пасторын сургаалыг сонсоод маш их ивээл авлаа гэж баяр хөөртэйгээр гэртээ ирсэн. И Жей руг пасторын Эсийн группын үйлчлэлд зориулсан Зургаан Өдрийн Манна, “Илчлэлт тайлбар” сургаалиас сүнслэг нууцуудыг сонсоод сэтгэл нь маш их хөдөлж байсан.

Бидний Африкийн үйлчлэл Бурханы удирдлаган дор Кеньд эхэлсэн

1991 оны 7 сард нөхөр маань Бурханы замчилсанаар Манмин Төв Сүмд бүртгэгдсэн. Тэр Хосео Их Сургуульд Английн Уран Зохиолын тэнхимд профессороор ажиллаж байхдаа нэг өдөр Африк руу явж үйлчлэх Ариун Сүнсний маш хүчтэй сануулга, ятгалгыг авч Найробигийн Их Сургуульд солилцооны профессороор ажиллах санал тавьсан.

Миний хувьд явж дассан сүмээ, мөн пастораа орхин явна гэдэг нь маш хэцүү байсан ч нөхөр маань 1994 оны 9 сард Манмин Сүмийн сайн мэдээ тунхаглагчаар албан ёсоор томилогдож дараа жилийнх нь 3 сард би араас нь очсон юм. Хэл, соёл, зан заншилыг нь сурч, амьдрал ахуйтай нь дасан зохицоход надад цаг хугацаа хэрэгтэй байлаа. И Жей руг пастораа болоод төрсөн нутаг, сүмийн нөхдөө үйлчлэлээ маш их санаж байлаа.

Эхлээд бид Кенийн сүмийн үйлчлэлд оролцож, Сөүлээс авчирсан Манмины видео бичлэгийг үзэж мөргөл үйлддэг байлаа. 1996 онд Найробигийн төвд Кеньяд үйлчлэлээ эхэлж, дараа жилийнх нь 10 сард манай нөхөр пастораар тослогдон томилогдсон. Тэгээд пасторууд болоод сүмийн удирдагч нарын семинарыг зохион байгуулж, И Жей руг пасторын тайлбарлаж өгсөн Бурханы ариун зар сайн мэдээг дамжуулж байв.

Тэд сургаалуудыг сонсоод урьд өмнө нь хэзээ ч сонсож байгаагүй хэн ч бидэнд И Жей руг пастор шиг ингэж тайлбарлан номлож байгаагүй гэж ярьж байсан. Тун ч удалгүй нөхөр маань сургалт, семинар, уулзалтуудыг Кень улсын маш олон газрууд болон Африкын бусад газарт



Эмэгтэйчүүдийн багийн удирдагч нарын хамт Юн Ин сүг (Найроби Манмин Сүм, Кень)

Хэзээ ч дуусашгүй Эзэний хайрыг Африк хүмүүст дамжуулахыг хүсдэг

хийсэн. Сайн мэдээ нэг их тараагүй газар байсан учраас хүнд хэцүү бэршээлтэй олон удаа тулгарч байсан. Тэр бүрд би түүнтэй хамт байж зураг авч, хоол хүнс бэлдэж, хувцас хунарыг нь угаах гэх мэт зүйлд тусладаг байв. Зам нь маш муу учраас манай машин дандаа л эвдэрдэг байсан.

Би багын сул дорой биетэй, машинд явж чадаагүй хүүхэд байсан болохоор хэцүү байдаг байлаа. Нэг удаа бид эвдэрсэн машинаа засварын газарт засуулах шаардлагатай болов. Хэдэн зуун километрийн зайтай засварын газраас машинаа авчраад байж байтал эргээд эвдэрчихсэн. Засварчин нь нэг юм мартаад хийчихсэн байсан. Эргүүлээд засахад 3 хоног шаардагдаж билээ.

Бид мөнгөө хэмнэх хадгалах хэрэгтэй байсан ч тэр үед бидэнд ямар ч сонголтгүй болж яаж ч чадалгүй нэг зочид буудалд буусан. Тэнд усгүй, хорхой шавьж ихтэй, хазуулаад хонож байсан үеэ одоо бодоход сайхан дурсамж болон үлдсэн.

Нөхөр маань ихэвчлэн үйлчлэл хийхээр ийш тийшээ явчихдаг байсан болохоор би пастор, ажилчидтайгаа үлддэг байсан. Тэр бүгдийг зохицуулна гэдэг надад тийм ч амархан байгаагүй. Тэр үед И Жей руг пасторын хүнд хэцүү нөхцөл байдлууд бодогдож, нөхрийгөө ирэхэд баяртай

уулзаж, энэ бүхнийг даван туулж чадна гээд талархаж, залбирдаг байв. Одоо манай пасторууд, ажилчид сургаалиар их өөрчлөгдөж, дуулгавартай пастор, ажилчид болж чадсан нь маш их талархуштай хэрэг билээ.

Угандагийн Нэгдсэн Их цуглааны дараа Найроби Манмин Ариун Сүм нээгдэж, асар хурдан сэргэв

2000 оны 7 сард И Жей руг пастор Уганда Нэгдсэн их цуглааныг Африкд хийсэн. Маш олон хүн тэргэнцэрээсээ босож явдаг болж, дүлий нь сонсож, сохор нь хараа орж, олон төрлийн өвчинтэй хүмүүс эдгэрч бүр ДОХ-той хүн хүртэл эдгэрэн Брханд алдрыг өргөж байлаа.

2000 оны 11 сард бид Найроби Манмин Ариун Сүмээ нээж, маш хурдан өдрөөс өдөрт өсөж гайхамшигууд бий болж байлаа. Сар болгон Гар алчуурын (Үйлс 19:11-12) эдгэрлийн цуглаан хийж олон хүн хариулт, ерөөлүүдийг авдаг байв.

Нэг Ням гаригт би итгэгчдийнхээ хоолыг бэлдчихсэн байтал олон хүн ирж жаахан будаатай байсан болохоор яаж ирсэн бүх хүнд будаагаа хүргэж хуваах вэ гэж бодон залбирах сэтгэлээр тогооныхоо тагийг нээтэл юу болсон гээч! Үнэхээр

гайхамшигтай юм болж агшаасан будаа маань ердийн хэмжээнээсээ бүр гурав дахин их агшсан бөгөөд том саваар тагандаа тултал сайхан агшсан байлаа!

Би ийм зүйлд ч хүртэл надтай хамт байдаг Бурханд талархаж Түүний хайрыг дүүрэн мэдэрч байлаа. Мөн итгэгч нартаа үйлчлэн, халамжилж И Жей руг пасторын залбирч өгсөн гар алчуураар дамжуулан Бурханы гайхмшигуудыг би өөрийн нүдээр харж байсан.

Нэгэн өдөр нэг ах дүүс маань амьсгалж ч чадахгүй, зүрх нь зогсоод үхэж байсан нэг хүнийг үүрсээр сүмд ирлээ. Гар алчуураар түүний төлөө залбирахад тэр хүн хэвийн болж өөрөө босоод гэр лүүгч явсан. Нэг эмэгтэй итгэгч маань атопик өвчнөөс болоод нүүр нь аймшигтай болсон байсан ч залбирал аваад юу ч үгүй цоо эрүүл болсон.

Манай зарим пастор, ахан дүүс маань чөтгөрт эзэмдүүлсэн нэгэн аймшигтай болсон охиныг авчирав. Би тэр охины төлөө залбирахад чөтгөр нь гарч яваад тэр дороо хэвийн болсон. Дараа нь тэр охины тухай сонсоход түүний гарнаас маш хурц тод гэрэл гарч байсан учраас нүдээ нээж чадахгүй байсан гэсэн. Энэ гэрэл бол И Жей руг пасторын залбирч өгсөн гар алчуурнаас цацарч байсан гэрэл юм.

Африкийн 55 орны хүмүүс рүү хандсан Бурханы хайрыг ухаарсан нь

Угийн хоолны шингэц муу миний биеийн минь өвчин 2011 оны эхээр хүндэрч ходоодны шархтай болсон байв. Өөрийн өнгөрсөн амьдралаа эргэн харж, зарим нэг зүйлийг Бурханы нүдээр харж, залбирч, зөв зохистой хийгээгүй байсан гэдгээ ухаарлаа. Түүнийхээ төлөө чин сэтгэлээсээ гэмшихэд Ариун Сүнс надад маш олон зүйлийг зааж сургасан юм. Бурхан надад агуу хайр, нигүүлсэлээ өгөхийг хүссэнийг би ойлгосон. Африкийн хүмүүсийн төлөө үйлчлэлийг Эзэнээс хүлээн авсан бөгөөд үүнийхээ төлөө гал мэт хүч чадлыг залбирлаар авах ёстой байсан. Харин би чадаагүй!

Бурхан надад зүүдээр дамжуулан нэг том илчлэлт өгсөн юм. Миний зүүдэнд нэг хүн ирээд “Уралдаан цэнгэлдэх хүрээлэнд аль хэдийн эхэлчихээд байхад чи яаж энд суугаад байж чадаж байна?” гэж хэлэв. Би талбай дээр гүйж байх ёстой байтал суугаад байсан. Тэр зүүдний дараа би чин сэтгэлээсээ хурдан өөрчлөгдөхийг хүсч Африкийн үйлчлэлийн төлөө бүх хүчээрээ ажиллахын төлөө гал халуун хичээнгүй залбирсан. Тэгтэл нөхөртөө туслах олон зүйл байсан бөгөөд намайг өөрчлөгдөхийг хүлээж байсан Бурхан Аавын хайрыг ойлгож, мэдэрсэн юм.

Бурхан намайг сүнслэг, сайхан сэтгэлтэй болж, Түүний хайрыг бусадтай хуваалцахыг хүсэж байсан юм. Үүний төлөө залбирч байх үед өдрөөс өдөрт бие маань эрүүлжиж байсан. 2014 оны 3 сарын 31нд сүгслэг итгэлтэй болж, сүнс рүү орох ивээлийг авсан. Одоо би нөхөртэйгээ хамт нэгдэн залбирч хүч чадвараа улам хөгжүүлж байна. Африкийн 55 оронд сайн мэдээ тарааж, өөрсдийгөө зориулан яваа миний нөхөр болон бусад сайн мэдээ тунхаглагч, пастор, сүмийн ажилчдад туслаж, Африкийн үйлчлэлийн төлөө агуу хүчирхэг нэгэн болохыг хүсэж байна. Хэзээ ч дуусч, ширгэхгүй үргэлж оргилон ундарч байдаг Бурханы агуу хайрыг хуваалцаж, Африкийн хүмүүст хүргэхийг хүсч байна. Бүх алдар, магтаал, талархалыг Эзэнд өргөж байна.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:
Г. Анхбаяр СМТ 976-91173712
976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@manmin.org
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин